



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 8/14

Ховд

Үндэсний аюулгүй байдлыг хангах
асуудал хариуцсан ажилтан
томилох тухай

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигийн хавсралтын 5.7, Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах асуудал хариуцсан ажилтнаар аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Н.Ганзоригийг томилсугай.

2. Н.Ганзоригт ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг үндсэн цалингийн 30 хувиар тооцож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч бөгөөд Санхүү, аж ахуйн тасгийн дарга /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмж, үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тусгайлсан чиг үүрэгтэй холбогдох байгууллага, албан тушаалтныг мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Н.Ганзоригт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

